

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4 – 11

1. *Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн үйл
ажиллагааны удирдамж батлах тухай/*

4 – 11

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
06 дугаар сарын 03-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 24 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 54.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 37 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Г.Ганбаатар, Ц.Мөнхбат, Ж.Чинбүрэн;

Чөлөөтэй: Т.Аубакир, Ж.Батжаргал, Ж.Бат-Эрдэнэ, Б.Бат-Эрдэнэ, С.Ганбаатар, С.Лүндэг, З.Мэндсайхан.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Ц.Рэнцэнтогтох, Хяналт шалгалтын газрын референт К.Пүрэвсүрэн нар байлцав.

“Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Б.Бейсен танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, М.Ганхүлэг, М.Мандхай нар үг хэлэв.

Б.Бейсен: “Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 6

Бүгд: 14

57.1 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг, М.Мандхай, С.Замира нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 78.6 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 18 минут үргэлжилж, 24 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 54.2 хувийн ирцтэйгээр 14 цаг 55 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН,
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
14 цаг 37 минут

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Бейсен: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 54.2 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. /алх цохив/

Хуралдааны ирцийг танилцуулъя.

Буланы Бейсен 3 дугаар тойрог ирсэн байна, Очирбатын Амгаланбаатар 2 дугаарт ирсэн байна, Пүрэвийн Батчимэг жагсаалтаар ирсэн байна, Мөнгөнцогийн Ганхүлэг 6 дугаар тойрог ирсэн байна, Цагаанхүүгийн Идэрбат 6 дугаар тойрог ирсэн байна, Мэндбаяр Мандхай жагсаалтаар ирсэн байна, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан 7 дугаар тойрог ирсэн байна, Бадрахын Найдалаа жагсаалтаар ирсэн байна, Нанзадын Наранбаатар 7 дугаар тойрог ирсэн байна, Ухнаагийн Отгонбаяр 6 дугаар тойрог ирсэн байна, Ренчинбямбын Сэддорж 7 дугаар тойрог ирсэн байна, Агвааналувсангийн Ундраа жагсаалтаар ирсэн байна, Болдын Уянгаа жагсаалтаар ирсэн байна.

Хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Байнгын хорооны тогтоолын төсөл. Өнгөрсөн Байнгын хорооны хурлаар бид ажлын хэсэг байгуулсан. Энэ ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамжийг батлах тухай.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу? Байхгүй байна. Хэлэлцэх асуудалд оръё.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл

/Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай/

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 13 дугаар тогтоолоор байгуулсан Малын генетикийн нөөцийн тухай хуулийн биелэлтэд хяналт шалгалт хийх, Монгол үйлдвэрийн омгийн адууны удмын санг хамгаалах асуудлыг судалж, санал, дүгнэлт гаргах,

шаардлагатай бол шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий “Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг Та бүхэнд тараасан болно.

“Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Асуулт асуух гишүүд байхгүй байна. /алх цохив/

“Ажлын хэсгийн үйл ажиллагааг удирдан батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан санал гаргаж, үг хэлэх гишүүд байна уу? Нэрс өгнө үү.

М.Ганхүлэг гишүүнээр тасаллаа. Ц.Идэрбат гишүүнээр тасаллаа.

Ц.Идэрбат гишүүн санал гаргаж, үг хэлье.

Ц.Идэрбат: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Тэгээд энэ малын генетикийн асуудал өөрөө малын ашиг шимтэй холбоотой ер нь нэлээн тийм цогц асуудал юм билээ.

Тэгээд Хөдөө аж ахуйн яамны байр суурь энэ асуудал дээр Байнгын хороо ажлын хэсэг гаргаад ажилла. Хөдөө аж ахуйн яам бол бас энэ дээр дэмжээд хамтраад ажиллая. Нөгөө талдаа бас энэ чинь шинжлэх ухаанчаар хандах ёстой ийм зүйл.

Тэгэхээр Шинжлэх ухааны академийг бас татан оролцуулах ийм талын юм бас Байнгын хорооны хуралдаан дээр танилцуулсан байгаа.

Тэгэхээр ер нь энэ ажлыг хийхэд өмнө нь энэ ажлыг хийх гэж оролдоод олон хүчин зүйлүүдэд нөлөөлөөд боломжгүй болсон юм шиг байгаа юм. Түүний нэг нь эндээс эрдэмтэд, ажлын хэсэг, яам шийдвэр гаргалаа гэхэд түүний шийдвэрлэх хөрөнгийн асуудал туйлын чухал юм билээ. Тийм.

Тэгэхээр ер нь энэ ажлын хэсэгт бас тодорхой хугацаа өгөөд, тэгээд ажлынхаа үр дүн, тайлангаа хурдан тавиад, түүнтэй холбоотой төсөв, хөрөнгөө хурдан тавиад, ингээд энэ намар Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсөв яригдахад энэ асуудлаа оруулаад явах нь зүйтэй юм. Тэгж байж энэ ажлын хэсгийн үр дүн гарна гэж харж байгаа.

Нөгөө талдаа манай зүүн бүсийн гишүүд энэ хурдан адууны тал дээр иргэд, олон нийтээс маш их хүсэлтүүд, шүүмжлэлүүд хүлээж авдаг. Түүний нэг нь монгол морийг эрлийзжүүлж байгаа энэ үйл явц бол одоо бас юманд бас нэг

хэмжээ хязгаар байдаг бол одоо бүр хэрээсээ хэтэрлээ гэдэг энэ асуудлыг ярьж байгаа юм.

Тэгээд монгол морины хувьд дэлхийд энэ тэвчээр хатуужил, үүгээрээ л дэлхийн томоохон дайн байлдаанд хүртэл гайхагдаж шагшигдсан ийм л адуу. Харамсалтай нь эрлийзжүүлснээс болоод ер нь энэ адууны тэсвэр тэвчээр гэдэг юм бас гол үзүүлэлт биш болж байна.

Тэгээд үүнээс болоод ер нь аятайхан шиг цасан шуурга, шамарганаар уруудаад ирэх чадвар байхгүй болж байна гэдэг ийм л зүйлүүдийг ярьж байгаа гэдгийг би энд онцолж хэлье гэж бодож байгаа.

Тэгээд Монгол наадам бол төрийн үйл ажиллагаа, төрийн наадам. Энэ морины эрлийз, энэ асуудал бол одоо ер нь хэрүүлгүй наадам байхгүй болголоо шүү дээ.

Тэгэхээр энэ дээр бүр тусгайлан адууны тал дээр анхаараасай гэж бас хүсэж байгаа юм. Баярлалаа.

Б.Бейсен: Энэ удирдамжийн 3.6 дээр ажлын хэсгийн гишүүд холбогдох байгууллагын удирдлага, албан тушаалтантай уулзаж, шаардлагатай мэдээ мэдээлэл авах, санал солилцох, шаардлагатай тохиолдолд танилцах ажлыг зохион байгуулна гээд ийм удирдлага дээр байгаа.

Энэ дээрээ шинжлэх ухааны байгууллагууд гээд бас оруулах нь зөв байх. Ажлын хэсгийн ахлагч М.Ганхүлэг гишүүн энэ дээрээ ямар саналтай байдаг юм?

М.Ганхүлэг: Үг маань явж байна уу?

Ц.Идэрбат гишүүний саналыг нэмээд тусгаад оруулъя гэж бодож байна. Сая Байнгын хорооны даргын хэлж байгаачлан ер нь мэргэжлийн холбоодууд, мөн төрийн болон бусад байгууллагуудын дэд ажлын хэсэг гаргаад бас ажиллуулъя гэсэн ийм бодолтой байгаа.

Тэгэхээр тэр ажлын хэсгийн бүрэлдэхүүнд бас шинжлэх ухааны байгууллагын төлөөллүүд, эрдэмтэн судлаачдыг оруулаад богино хугацаанд хамтран ажиллая гэсэн ийм бодолтой байна.

Б.Бейсен: Сая Ц.Идэрбат гишүүн бас чухал санал гаргалаа.

Монгол адууны генетик удмын санг хамгаалах асуудал чухал байгаа. Одоо хөдөөгийн малчид, ард иргэд монгол наадмын тал дээр нэлээн санал гаргаж ажиллаж байгаа. Эрлийз адууны асуудлыг бас ярьж байгаа.

Тийм учраас энэ дээр саяын 3.6 дээр “санал солилцох” гэдэг дээр “шинжлэх ухааны байгууллага” гээд оруулах нь зөв байх. Тийм ээ. Хоёр мэргэжлийн холбоо оруулсан.

Редакцын засвар хийгээд энд оруулъя.

М.Ганхүлэг гишүүн саналаа хэлье. Үг хэлээд.

М.Ганхүлэг: Байнгын хорооны гишүүдийнхээ саяын саналуудыг бас нэмэлтээр оруулъя.

Ялангуяа тэр академийн оролцоог хангах чиглэл дээр бас ажиллая. Мөн дээрээс нь мэргэжлийн холбоод өөрсдийнхөө байр суурийг илэрхийлээд хамтран ажиллахаа бас илэрхийлсэн байгаа.

Түрүүн хэлсэнчлэн дэд ажлын хэсэг бас байгуулаад, илүү шуурхай ажиллаад явъя.

Ц.Идэрбат гишүүний гаргаж байгаа тэр хөрөнгө, санхүүтэй холбогдолтой асуудлыг дүгнэлт, санал дээрээ оруулж ирээд Байнгын хорооны хороогоороо хэлэлцүүлнэ.

Өнгөрсөн долоо хоногт хуралдсан Малын генетик нөөцийн тухай хууль 2017 онд батлагдсан байгаа.

Энэхүү хуулийн хэрэгжилтийг хяналт шалгалт хийх, мөн дээрээс нь тусгайлан Монгол үйлдвэрийн омгийн адууны удмын санг хамгаалах асуудлаар богино хугацаанд ажиллая гэсэн энэ санаачилгыг гаргаад ингээд ажлын хэсэг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаад, миний бие ахалж байгаа.

Ажлын хэсгийн гишүүдээр М.Бадамсүрэн гишүүн, С.Ганбаатар гишүүн, С.Замира гишүүн, У.Отгонбаяр гишүүд ажиллахаар болсон юм.

Ингээд бид бүхэн эхний байдлаар ажлын хэсгийнхээ удирдамжийг Байнгын хороогоороо өнөөдөр оруулж ирж танилцуулж байгаа. Ерөнхий агуулгуудыг багтааж оруулж ирсэн.

Энэхүү удирдамж батлагдсанаараа бид бүхэн ажлын хэсгийн төлөвлөгөө, дэд ажлын хэсгээ байгуулаад тодорхой санал, дүгнэлтээ боловсруулах чиглэлээрээ шуурхай ажиллаад явна гэсэн төлөвлөгөөтэй байгаагаа Байнгын хорооны гишүүддээ илэрхийлье.

Удирдамж дээр бид хэд ажлын хэсэг дээр ярилцаж байгаад 3.1.6 дээрх агуулга арай нэг өөр агуулгаар орсон байна. Үүнийг протоколд тэмдэглүүлээд засварлах байдлаар оруулъя.

Импортын адуу оруулж ирж байгаатай холбогдолтой тодорхой Засгийн газрын журмаар зохицуулалтууд хийгдэж байгаа.

Тэгэхээр тэрхүү Засгийн газрын журмын хэрэгжилт, мөн дээрээс нь импортоор оруулж ирсэн адууны хувьд тодорхой бүс нутгуудад үржүүлэх, хээлтүүлэг явуулах гээд тусгай заалтуудыг тавьсан байдаг.

Гэтэл өнөөдөр өөрийн бүс нутагтаа биш маш замбараагүйгээр энэхүү үйл ажиллагаа явагдаж байгаатай холбогдолтой асуудлыг судалъя гэсэн энэ агуулгыг оруулж ирье гэсэн агуулга. Үг, үсгийн хувьд, утга найруулгын хувьд бүрэн илэрхийлэгдэхээргүйгээр орсон байна.

Тийм учраас 3.1.6 дээрх энэхүү агуулгыг саяын ярьсан саналаар өөрчлөх энэ саналыг бас оруулъя гэж үг авсан юм.

Б.Бейсен: М.Мандхай гишүүн.

М.Мандхай: Би ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухайтай холбоотойгоор бас нэг ажлыг ажлын хэсгийнхэнд тусгаж өгөөч ээ гэж хэлмээр байгаа юм.

Тэр нь юу гэхээр малын чанарыг сайжруулахад чиглэсэн төрийн өмчит цөм сүргийн аж ахуй гэж байгаа. Сүүлийн Байнгын хорооны тайлан дээр 3 мянган мал сүрэг байгаа гэсэн тоо хэлж байсан. Тэгэхээр энэ Малын удмын сангийн Үндэсний төвд харьяалагддаг.

Тэгэхээр яг энэ тоо хэд байна? Яг ямар ямар аймгууд дээр байна? Одоо үүнийг өсөж үржүүлэх дээр юу хийгдсэн юм? Ер нь 3 мянга гэдэг тоо хангалтгүй тоо байгаа учраас энэ дээр бас нэлээн судалгаа, шинжилгээ хийж тооцоололыг нь хармаар байна.

Тэгээд ер нь бид цаашдаа бүсчилсэн хөгжлийн бодлогод бүх бүсэд цөм сүргийн аж ахуйг дэмжихээр заасан байгаа. Тэгэхээр үүнийг яаж уялдуулах вэ?

Мөн хувийн аж ахуйг бодлогоор яаж дэмжиж өгөх вэ гэдэг дээр манай ажлын хэсгийнхэн судлаад, энэ дээр зөвлөмж, дүгнэлтээ гаргахдаа тусгаж өгөөч ээ гэсэн ийм хүсэлт байна.

Б.Бейсен: М.Ганхүлэг гишүүн хариулъя.

М.Ганхүлэг: Ажлын хэсгийн хүрээг харахдаа бид юун дээр суурилах вэ гэдэг дээр анхаарах хэрэгтэй байгаа юм.

Ялангуяа одоо энэ Генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хоёр, гурван томоохон суурь судалгаанууд хийгдэх ёстой байсан байгаа. 3 жил тутамд малын генетик нөөцийн төлөв байдлын судалгааг хийх ёстой байсан боловч бидэнд танилцуулсан мэдээллээр 2018 оноос хойш хийгдээгүй байгаа юм.

Тэгэхээр энэ удаагийн ажлын хэсгээр ерөнхий бодлогын болон томоохон өөрчлөлтийн агуулгуудыг бүрэн дүүрэн гаргахад бас жоохон өрөөсгөл байгаа. Манай Байнгын хорооны гишүүд маань анхаарах нь зөв.

Тэгэхээр тодорхой хуулийн хэрэгжилтийн явцыг ерөнхийд нь дүгнээд, саяын ярьсан суурь судалгаануудыг хийх чиглэлүүдийг ойрын хугацаандаа үндсэндээ гаргаад, төсөв санхүүтэй холбогдолтой бусад асуудлуудыг нь яаж шийдэх вэ гэдэг дээр тодорхой шийдлүүдээ гаргах агуулга руугаа ажлын хэсэг нь төвлөрөх нь зөв байгаа юм.

Тэгээд суурь судалгааны үр дүнд цогцоор нь саяын ярьж байгаа малын удмын сангийн үйл ажиллагаа, малын ашиг шимтэй холбогдолтой асуудал, бүтэцлэн хөгжүүлэхтэй холбогдолтой асуудлыг цогцоор нь тухайн гарч ирсэн судалгаан дээр үндэслэж хийх нь илүү үр нөлөөтэй болно гэж харж байгаа юм гэдгийг хэлье.

Ямар ч байсан ажлын хэсгийн гишүүдтэйгээ саяын саналыг ярилцаж байгаад төлөвлөгөөндөө ямар байдлаар оруулж ажиллах вэ гэдгийг анхаарч ажиллая гэж бодож байна.

Б.Бейсен: Байнгын хорооны хуралд Сонгобайн Замираа гишүүн ирсэн байна.

Сая Ц.Идэрбат гишүүн, М.Ганхүлэг гишүүн, М.Мандхай нарын гишүүд үнэтэй санал ярьж байна.

Энэ 3.3 дээр нь Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Биологийн хүрээлэнгийн генетикийн лабораторитой бас хамтарч ажиллах талаар дурдсан байгаа.

Мөн 3.4 дээр Монгол Улсын хилээр импортоор оруулж ирсэн таван хошуу малын тоо, ялангуяа адууны тоо хэмжээ, гаалийн татварын хэмжээ, гарал үүслийн талаарх Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газрын статистик

мэдээлэл цуглуулах гээд байгаа. Энэ бас дүн шинжилгээ хийхэд хэрэгтэй байгаа юм.

Нөгөө талаар хамгийн гол нь монгол үйлдвэрийн омгийн адууны удмын санг хамгаалах асуудлаар малчид, уяачдыг хамруулсан хэлэлцүүлэг зохион байгуулна гэсэн байгаа. Ажлын хэсгийн ахлагч энэ дээр анхаарч ажиллах нь зүйтэй байх гэж бодож байна.

Энэ ажлын удирдамжийг гишүүдэд тараасан учраас дэлгэрэнгүй танилцуулах шаардлагагүй гэж бодож байна.

Гишүүд санал гаргаж, үг гэж дууслаа. /алх цохив/

“Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг уншиж танилцуулах нь зөв байх гэж бодож байна.

“Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.3, 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 13 дугаар тогтоолоор байгуулагдсан Малын генетик нөөцийн тухай хуулийн биелэлтэд хяналт шалгалт хийх, Монгол үүлдэр, омгийн адууны удмын санг хамгаалах асуудлыг судалж санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамжийг хавсралтаар баталсугай.

2.Ажлын хэсгийн санал, дүгнэлт, шийдвэрийн төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5, 9.6, 9.8 дахь хэсэгт заасны дагуу бэлтгэж, Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулгын хугацаанд багтааж Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхийг Ажлын хэсгийн ахлагч М.Ганхүлэгт үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын биелэлтийг хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо Б.Бейсенд даалгасугай гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Энэ тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

П.Батчимэг гишүүн, М.Мандхай гишүүн хоёрыг дэмжсэнээр аваарай. С.Замира гишүүнийг. 14 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, тогтоолын төсөл батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүдэд баярлалаа. /алх цохив/

Хуралдаан 18 минут үргэлжилж, 14 цаг 55 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД